



Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл
2026 ОНЫ 06 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2026 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2026 ОНЫ 6 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-10
1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/	6-7
2.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг	7-9
3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл / Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/	9-10
/	

**Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 18-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Н.Наранбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 45 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: П.Мөнхтулга, Б.Түвшин, Г.Тэмүүлэн;
Чөлөөтэй: Д.Батбаяр, Г.Ганбаатар, П.Ганзориг, Ц.Даваасүрэн,
Д.Жаргалсайхан, Ч.Номин, Д.Пүрэвдаваа;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Баясгалан, Х.Болормаа, Ж.Ганбаатар.

Нэг.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн санал хураалтаар үргэлжлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалгаагүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэний дагуу санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: 1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 7

Бүгд: 16
56.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Р.Батболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 9 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэний дагуу санал хураалт явуулав.

Н.Наранбаатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтын “албан татвар төлөгчийн” гэснийг “иргэний” гэж, “аялал жуулчлалын бүс гэснийг”, улсын аялал жуулчлалын бүс болон улсын тусгай хамгаалалттай газар нутгийн бүсэд баригдсанаас бусад” гэж өөрчлөх;

2.Төслийн 2 дугаар зүйлийн нэг дэх заалтын 21.2 дахь хэсгийг хасаж, 7 дугаар зүйл болгох.

“7 дугаар зүйл. Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналуудаар дахин санал хураалт явуулъя гэсэн горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17

82.4 хувь буюу хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Н.Наранбаатар: 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтын “албан татвар төлөгчийн” гэснийг “иргэний” гэж, “аялал жуулчлалын бүс гэснийг “, улсын аялал жуулчлалын бүс болон улсын ТХГН-ийн бүсэд баригдсанаас бусад” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 4
Бүгд: 17
76.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Н.Наранбаатар: 2.Төслийн 2 дугаар зүйлийн нэг дэх заалтын 21.2 дахь хэсгийг хасаж, 7 дугаар зүйл болгох.

“7 дугаар зүйл. Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 3
Бүгд: 17
82.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 9 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Ч.Чимидсүрэн, Татварын ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цогтнаран, мөн газрын Судалгаа, шинжилгээний хэлтсийн дарга Б.Болд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын асуудал эрхлэх газрын Төсвийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, зөвлөх Бат.Баярмаа, референт С.Төрмөнх, С.Тэгшжаргал нар байлцав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Энхтүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 18 минут үргэлжилж, 30 гишүүнээс 17 гишүүн хүрэлцэн ирж, 56.7 хувийн ирцтэйгээр 10 цаг 03 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Н.НАРАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2026 оны 6 дугаар сарын 18-ны өдөр,
Пүрэв гараг Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим 09 цаг 45 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Наранбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Төсвийн байнгын хорооны олонх хүрэлцэн ирж байнгын хорооны ирц 53.3 хувьтай бүрдсэн тул 2026 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийн гишүүний сонгогдсон тойрог нэрээр нь танилцуулна. Норовын Алтанхуяг, Ренчиндоржийн Батболд, Пүрэвийн Ганзориг, Баатаржавын Мөнхсоёл, Даваагийн Цогтбаатар, Доржсүрэнгийн Үүрийнтуяа, Тилеуханы хааны Аубакир, Жигжидийн Батжаргал, Хассуурийн Ганхуяг, Нанзадын Наранбаатар, Баттогтохын Чойжилсүрэн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Хүрэлбаатарын Булгантуяа, Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан, Пүрэвжавын Сайнзориг, Дашцэрэнгийн Энхтүвшин нарын гишүүд ирсэн байна.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Засгийн газар 2026 оны 5 сарын 7-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг,

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

3.Аж ахуйн нэгжийн орологын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг нарын 2 гишүүн 2026 оны 3 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу? Байхгүй байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Гишүүд танхимдаа орж ирээрэй. Санал хураалт явагдана.

Нэг.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2026.05.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг, үргэлжилнэ/

Нэг дэх асуудал. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулъя.

2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хуулийн төслийн талаар гишүүд асуулт асууж хариулт авч дууссан.

Өнөөдрийн хуралдаан санал хураалтаар эхэлнэ.

Гишүүд орж ирээрэй Байнгын хорооны хуралд. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуралдаан даргалагчаас Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу гүйцээн боловсруулах чиглэл өгсний дагуу ажлын хэсгээс бэлтгэсэн нэг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна аа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар тийм сая уншчихсан ажлын хэсгээс бэлтгэсэн нэг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд санал хураалтад бэлтгэе. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтад заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

56.3 хувиар дэмжигдлээ.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? НӨАТ-ыг хэн танилцуулав? Батболд гишүүн танилцуулчих уу? Батболд гишүүн танилцуулна.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

9.53 цаг

Хоёр дахь асуудал.

Хоёр.Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаа нарын 32 гишүүн өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг

Засгийн газар болон Улсын Их Хурлын гишүүн Баярмаа нарын 32 гишүүнээс өргөн мэдүүлсэн Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нэгтгэсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Өмнөх ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Горимын санал Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Энэ чуулган дээр хураачихсан санал дээр найруулгын жоохон өөрчлөлт орж байгаа. Найруулгын өөрчлөлт нь юу вэ гэхээр аялал жуулчлалын бус орон сууц гэдгийг аялал жуулчлалын бүс болон тусгай хамгаалалттай газар, иргэний орон сууц гэдгээр нь болгож байгаа юм. Тэгэхгүй бол нөгөө барилгын компаниуд ч байдаг юм уу. Татвар төлөгч гэхээр компаниуд нь ч ороод, иргэн нь ч ороод бүгдээрээ татварын хөнгөлөлт эдлэх гээд байгаа болохоор энэ тусгай хамгаалалттай газар орон сууцны татварын хөнгөлөлт эдлүүлэхгүй ээ гэдэг л ийм зүйл заалт орж байгаа юм.

Тэгээд иргэний гэдгийг нь тодотгож байгаа шүү. Тэгээд энэ заавал ч үгүй 3-ны 2-оор яах ёстой юм байна лээ. Өмнө нь нөгөө чуулганы хуралдаанд санал хураачихсан болохоор. Тэгээд гишүүд дэмжээд өгөөрэй гэж хүсье.

Н.Наранбаатар: Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа.

Горимын саналаар санал хураалт явуулна. Гишүүдээ санал хураалтад бэлтгээрэй.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураах. Аан горимын саналаар санал хураана.

Санал хураалт.

82.4 хувиар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.2.3-т заасны дагуу нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалт шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд санал хураалт явуулж болно гэсний дагуу ажлын хэсгээс бэлтгэсэн 2 саналаар санал хураалт явуулна.

Саналын томъёоллыг уншиж танилцуулна.

Энэ дээр Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтад заасны дагуу хураалгах санал.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 22.1.11 дэх заалтын “албан татвар төлөгчийн” гэснийг “иргэний” гэж, “аялал жуулчлалын бүс гэснийг”, улсын аялал жуулчлалын бүс болон улсын ТХГН-ийн бүсэд баригдсанаас бусад” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

76.5 хувиар дэмжигдлээ.

2.Төслийн 2 дугаар зүйлийн нэг дэх заалтын 21.2 дахь хэсгийг хасаж, 7 дугаар зүйл болгох.

“7 дугаар зүйл. Энэ зүйлийн 21.1.1 дэх заалтыг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал, 21.1.2 дахь заалтыг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өд өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

82.4 хувиар дэмжигдлээ.

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах вэ? Хувь хүний... танилцуулах хүн байхгүй юу.

Ганхуяг гишүүн танилцуулна. Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

9.58 цаг

Гурав дахь асуудал.

Гурав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 2 гишүүн 2026.03.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, нэгтгэсэн төсөл, эцсийн хэлэлцүүлэг/

Улсын Их Хурлын гишүүн Сайнзориг, Бат-Эрдэнэ нараас өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн хэвээрээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг та бүхэнд тараасан.

Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. ААНОАТ-ын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулга чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн хэн танилцуулах уу? Сайнзориг гишүүн танилцуулна.

Болохгүй юм байна. Өөр танилцуулах хүн байна уу ААН-ийг? Нөгөө цахим тоглоом. Энхтүвшин гишүүн танилцуулна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулахдаа хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Төсвийн байнгын хорооны хуралдаан дууслаа.

Байнгын хорооны гишүүд ажлын хэсэгт баярлалаа.

Нөгөөдөх чинь яасан шүү дээ.

10.03 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА